

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН

2025 оны 06 дугаар сарын 05

ATA14401 9025010818 5890683

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 06 дугаар сарын 05

Дугаар 07

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 14:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Хамтын ажиллагааны хүрээнд “Координат Чойсе” ХХК-иас паркт хандиваар ширээ, сандал, ширээний микрофон авах тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 06 дугаар сарын 05

Дугаар 07

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот-хурлын танхимд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 14:30 цагт эхэлж 15:00 цагт дуусгав.

Хуралд:

Дарга	Н.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга	О.Чулуун-Эрдэнэ
Гишүүд	Г.Ганцэцэг
	Б.Түмэнжаргал
	Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хамтын ажиллагааны хүрээнд “Координат Чойсе” ХХК-иас паркт хандиваар ширээ, сандал, ширээний микрофон авах тухай

СОНССОН НЬ: Байгууллагад шаардлагатай байгаа хурлын өрөөний ширээ болон сандалнуудыг парктай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй “Координат чойсе” ХХК-иас хандиваар бидэнд авч өгөх хүсэлт тавьсан.

Н.Пүрэвсүрэн: 2 давхрын 201 тоот хурлын өрөөг тохижуулж засвар хийж ухаалаг дэлгэц худалдан авч тавьсан. Гэвч бид ширээ сандалны хомсдолтой, олон хүмүүс ирж уулзалт зөвлөгөөн хийхэд бусад өрөөнөөс болон өөрсдийн ширээ сандлыг тавьж өгч байна. Энэ нөхцөл байдлыг ажигласан “Координат чойсе” ХХК-иас хамтын ажиллагааны хүрээнд бидэнд ширээ сандал авч өгөх хүсэлт тавьсан. Энэ хүсэлтийг хүлээн авч хомсдолтой байдлаас гарах боломж бидэнд нээгдээд байна. Одоогоор бидэнд хичнээн ширээ сандалны хэрэгцээ байгаа вэ? Мөн тус компаниас гаргасан хүсэлтэд саналтай гишүүн байна уу? Саналаа хэлнэ үү.

Г.Ганцэцэг: Ийм боломж үүсэж байхад эсэргүүцэх саналгүй байна. Миний тооцоолсноор хурлын зааланд 20ш ширээ, 70ш сандал байвал хангалттай гэж бодогдсон.

О.Чулуун-Эрдэнэ: Тийм шүү. Хамтын ажиллагааны хүрээнд ийм сайхан санал гаргаж байгаад тус компанийн хамт олонд баярлаж байна. Бид ширээ сандалтай боллоо, өсгөгч чадлын оролттой боллоо. Нэмэлтээр 20ш микрофон бас хэрэгцээтэй л байна. Энэ хүсэлтийг нэмж тавьбал яадаг бол?

Б.Түмэнжаргал: Хандиваар ширээ сандал микрофон хүлээн авахад эсэргүүцэх зүйлгүй ээ.

Б.Болортуяа: Тэгвэл хандиваар тэдгээр зүйлсийг хүлээн авч байгууллагын өмчдөө бүртгэж авъя.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Координат чойсе” ХХК-иас

- Хурлын ширээ – 20ш – 5,600,000
- Сандал – 70ш – 13,300,000
- Микрофон – 20ш – 5,400,000

Нийт – 24,300,000 төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил хандиваар авахаар шийдвэрлэв.

- Тус хөрөнгийг хүлээн авч байгууллагын холбогдох дансанд бүртгэн авахыг Нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Нарийн бичгийн дарга

Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/

